



АМГАЛАН АМАРЖИХ ГАЗАР
ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЭМНЭЛГИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2022 оны 03 сарын 11 өдөр

Дугаар А/17

Улаанбаатар хот

Жагсаалт батлах тухай

Амаржих газрын эмч, мэргэжилтэн, ажилтанд Эрүүл мэндийн тухай хууль, Төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагааны MNS 6330:2017 стандарт болон эрүүл мэндийн салбарт хэрэгжиж байгаа эмчилгээ үйлчилгээний бусад стандарт, удирдамж, Сайдын тушаалаас Эх барих, эмэгтэйчүүд, нярайн тусламж, эмэгтэйчүүдийн хавдар, мэс засал, мэдээгүйжүүлэг эрчимт эмчилгээний хүрээнд хэрэгжих стандарт удирдамж, тушаалыг жагсаалтыг гарган хэрэгжүүлж ажиллах, хэрэгжилтэнд хяналт тавих зорилгоор ТУШААХ нь:

1. Амаржих газар төрөлжсөн мэргэшлийн эмчилгээ үйлчилгээнд хэрэглэгдэж байгаа хууль эрх зүй, стратеги, стандарт, сайдын тушаал, удирдамжийн шинэчлэсэн жагсаалтыг хавсралтаар баталсугай.
2. Амаржих газрын эмчилгээ, тусламж үйлчилгээний стандарт удирдамж, хууль эрх зүй, тушаалыг хэрэгжүүлэхэд арга зүйгээр ханган ажиллахыг Эмнэлзүй эрхэлсэн дэд захирал /С.Ганболд/-д үүрэг болгосугай.
3. Стандартыг худалдан авч, олшруулж, эмч, мэргэжилтэнд тараан өгөхөд зарцуулагдах төсвийг тооцон гаргахыг Ахлах нягтлан бодогч /Б.Дангаа/-д үүрэг болгосугай.
4. Стандарт, тушаал, удирдамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлын алба, сувилахуйн алба, эмзүйн алба, халдвараас сэргийлэх хяналтын алба, тасгийн эрхлэгч, арга зүйч нарт үүрэг болгосугай.
5. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Амаржих газрыг даргын 2016 оны А/30 тоот тушаалыг хүчингүй болгосонд тооцсугай.

ЗАХИРАЛ

Ц.БАТБОЛД

